


Үндэсний хөгжлийн газрын даргын  
2018 оны 03 сарын 03 ны өдрийн  
А.3.1 дугаар тушаалын хавсралт



**ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЯНАН ҮЗЭХ БОЛОН  
ОЛОН УЛСЫН ШИЛДЭГ ТУРШЛАГАД ҮНДЭСЛЭН ТҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ  
ХУВИЛБАР БОЛОВСРУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ ЗӨВЛӨХИЙН АЖЛЫН ДААЛГАВАР**

- Зөвлөх үйлчилгээний нэр:** Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хянан үзэж, түүнийг сайжруулах хувилбар боловсруулах зөвлөх үйлчилгээ
- Гэрээний төрөл:** Хувь хүн (баг байж болно)
- Хэрэгжүүлэгч байгууллага:** Үндэсний Хөгжлийн Газар (ҮХГ)
- Даалгаврын хугацаа:** 1 сар

## **1. ОРШИЛ**

Монгол Улс 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоог халснаас хойш стратегийн, урт хугацааны төлөвлөлтийг бий болгох хэд хэдэн оролдлого хийж байжээ. Гэвч, төлөвлөлтийг бүрдүүлэх, боловсронгуй болгох ажил нь бодит байдалтай нийцгүй, төсөвтэй уялдаагүйн улмаас төдийлөн үр дүнд хүрээгүй байна. Мөн дөрвөн жил тутам болдог сонгуулийн мөчлөгтэй уялдан Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл ойр ойрхон өөрчлөгдөж, залгамж чанар орхицдог болон уялдаа, үндэслэл муутай бодлогын хэт олон баримт бичгүүдийг салбар бүрээр баталж улс орны хөгжлийн нэгдмэл чанарыг алдагдуулахад хүргэж байв. Намын сонгуулийн мөрийн хөтөлбөр болон шинээр бүрэлдсэн засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр нь үндэсний хэмжээний хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг хэмээн үзэж ирсэн.

НҮБ-ын 70 дугаар чуулганаар батлагдсан дэлхийн Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх 17 зорилго нь төлөвлөлтийн тогтолцоог хөгжүүлэхэд шинэ түлхэц болов. Уг зорилгыг дэвшүүлсний дараа Монгол Улсын Их Хурал 2015 оны 11-р сард Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг баталснаар хөгжлийн бодлогыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх болон түүнд хяналт шинжилгээ хийх суурь зарчмуудыг тодорхойлж, оролцогч талуудын эрх, үүрэг хэм хэмжээг тогтоож үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцооны эрх зүйн орчинг бүрдүүлсэн юм.

Засгийн газар Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмыг 2016 онд батлан гаргасан нь үндэсний болон орон нутгийн түвшинд урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулах болон хэрэгжүүлэх эрх зүйн үндэс суурь болж ирсэн. Иймд манай орны хөгжлийн урт хугацааны стратеги болох Улсын Их

Хурлаар 2016 оны 2 дугаар сард батлагдсан Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал-2030-ыг хэрэгжүүлэх гол механизм нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон дээрх нийтлэг журам мөн билээ.

Хэдийгээр холбогдох хууль, тогтоомж дүрэм, журам батлагдсан боловч, хөгжлийн бодлогын босоо болон хөндлөн уялдаа холбоог хангах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан байгууллагыг бэхжүүлэх, улс орны хэмжээнд бодлогын нэгдмэл, залгамж чанарыг хангах, төлөвлөлт, хариуцлагын механизмыг илүү тодорхой болгох чиглэлд хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоог илүү бэхжүүлэх, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг сайжруулах шаардлага байсаар байна. Иймээс өмнө боловсруулсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хувилбаруудыг олон улсын шилдэг туршлагад үндэслэн сайжруулж, эцэслэн боловсруулж улмаар УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлэх шаардлага үүсээд байна.

## **2. АЖЛЫН ЗОРИЛГО**

Олон улсын шилдэг туршлагын харьцуулсан судалгаа, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр өмнө боловсруулагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах эсвэл хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон улсын зөвлөлтэй хамтран эцэслэн боловсруулах.

## **3. ХИЙХ АЖЛЫН ХҮРЭЭ**

ҮХГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (ҮХГ-т байгуулагдсан ажлын хэсгийн дарга)-ын өгөх ерөнхий чиглэлийн дагуу зөвлөх нь дараах ажлыг гүйцэтгэнэ:

1. Хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлагыг нарийвчлан тодорхойлж, өмнө боловсруулсан төслийн хувилбаруудыг судлах
2. Хөгжлийн бодлогын нэгдмэл уялдааг хангах, төлөвлөлтийн механизмыг нарийвчлан тодорхойлох, байгууллагын болон хариуцлагын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх үүднээс нарийвчилсан шинжилгээ, чиг үүрэг, эрх зүйн үнэлгээ хийх
3. Бүс нутгийн болон олон улсын шилдэг туршлагатай харьцуулсан шинжилгээ хийх
4. Хуулийн төслийн хувилбар, хуулийн үзэл баримтлал болон бусад шаардагдах баримт бичгийн бүрдлийг олон улсын зөвлөлтэй хамт боловсруулах
5. Хуулийн төслийг холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлж, санал зөвлөмжийг тусган эцэслэх

Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль, эрх зүй болон тогтолцооны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, улмаар сайжруулах талаар зөвлөмж гаргах олон улсын зөвлөхийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр гэрээлэн ажиллуулна. Зөвлөх нь Ажлын хүрээнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхтэй олон улсын зөвлөлтэй хамтран ажиллана.

#### 4. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Дээр дурдсан үйл ажиллагааг гүйцэтгэснээр, зөвлөх үйлчилгээ нь дараах үр дүнд хүрсэн байна.

| Но | Хүрэх үр дүн  | Хугацаа   |
|----|---|---|
| 1. | Хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, харьцуулсан шинжилгээ, эрх зүйн үнэлгээ хийх ажлын аргачлал, арга зүй, харьцуулсан шинжилгээ хийх улсуудыг сонгосон үндэслэлийн талаар танилцуулга.  | Гэрээ<br>байгуулснаас хойш<br>7 хоногийн дотор  |
| 2. | Харьцуулсан шинжилгээний үр дүн, хөгжлийн бодлогын үялдаа, байгууллагын болон хариуцлагын үр дүнтэй тогтолцоог хангах нарийвчилсан шинжилгээ, эрх зүйн үнэлгээний үр дүнгийн талаар тайлан болон хуулийн төслийн хувилбарыг шаардагдах баримт бичгийн бүрдэл /үзэл баримтлал, төслийн танилцуулга, хэрэгцээ, төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо, холбогдох хууль тогтоомжид орох нэмэлт, өөрчлөлтүүдийн талаар танилцуулга г.м/-ийн хамт ҮХГ-н Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс болон холбогдох зөвлөхүүдэд танилцуулна. | Гэрээ<br>байгуулснаас хойш<br>20 хоногийн дотор |
| 3. | Хуулийн төслийг холбогдох байгууллага, судлаачдаар хэлэлцүүлсний үндсэн дээр эцэслэн боловсруулсан төслийн хувилбар   | Гэрээ<br>байгуулснаас хойш<br>30 хоногийн дотор |

Дээрх үр дүнг ҮХГ-н Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргаар хянуулж, зөвшөөрүүлсэн байх шаардлагатай ба Монгол хэл дээрх цахим хувилбарыг мөн хүлээлгэн өгнө.

#### Б. БАГИЙН БҮТЭЙ, БҮРЭЛДЭХҮҮН

Уг зөвлөх үйлчилгээг хувь хүн (баг байж болно) 1 сарын хугацаанд гүйцэтгэнэ.

#### 6. ЗӨВЛӨХ(ҮҮД)-Д ТАВИГДАХ ШААРДЛАГА

**Зөвлөх(үүд) нь** дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хөгжлийн бодлого, Төрийн удирдлага эсвэл Эдийн засгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх, Эрх зүйн магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байх /эдгээр чиглэлээр бусад сургалтад хамрагдсан нь давуу тал болно/

- Төрийн захиргааны байгууллагад эсвэл Төрийн байгууллагад бодлогын зөвлөхөөр 10 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх, эрх зүйн судалгааны эсвэл эрдэм шинжилгээний байгууллагад 10 болон түүнээс дээш жил мэргэжлээрээ ажилласан туршлагатай байх
- Салбарын болон салбар хоорондын бодлогын судалгаа, бодлогын шинжилгээ, бодлого боловсруулалт, төлөвлөлт, төсөвлөлтийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай /эрх зүйн харьцуулсан судалгаа, эрх зүйн дүгнэлт, үнэлгээний тайлан боловсруулж байсан туршлагатай бол давуу тал болно/
- Хууль бүтээх ажиллагааны туршлагатай, хууль зүйн техникийг ашиглах ур чадвартай байх
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 болон бусад Үндэсний хууль тогтоомжийн талаар өргөн мэдлэгтэй байх
- Тайлан, бичиг баримт боловсруулах бичгийн өндөр чадвартай байх
- Компьютер дээр болон интернет орчинд ажиллах чадвартай байх
- Англи хэлээр зохих түвшинд уншиж ойлгох чадвартай байх

## **7. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БОЛОН ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ**

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх зөвлөх нь ҮХГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын өгөх чиглэл, зааврын дагуу ажиллана. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь одоо байгаа нэмэлт, өөрчлөлтийн төсөл болон бусад холбогдох баримт бичгийг гаргаж өгнө.

## **8. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

Төлбөрийг үр дүнг хүлээлгэж өгсөн болон Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга гэрээнд заасан үр дүнг хүлээн авсныг баталгаажуулсны үндсэн дээр олгоно.